



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/5

Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан сумын Засаг даргын Тамгын газарт худалдан авах ажиллагааг зохион байгуулах захиалагчийн эрхийг шилжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулж, тайлагнахыг Дархан сумын Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2018 оны  
01 дугаар сарын 2 өдрийн А/Б  
дугаар захирамжийн хавсралт

### ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(мян.төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугаца а	Төсөвт өртөг	2018 онд санхүүжих дүн
1	Дархан сумын ЗДТГ-т авто машин	2018	45 000,0	45 000,0 /ОНТөсөв/